



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 172

Арвайхээр


**Хяналт-шинжилгээний талаар авах арга
хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Засгийн газрын 1996 оны “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоолын 4.д дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2011-2019 оны үйл ажиллагааны холбогдолтой шийдвэрүүдэд хийсэн хяналт-шинжилгээний зөвлөмж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн хүчингүй болгох шийдвэрийн жагсаалтыг нэгдүгээр, шинэчлэн боловсруулах, өөрчлөн найруулах шийдвэрийн жагсаалтыг хоёрдугаар, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах шийдвэрийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн найруулагдсан, өөрчлөлт орсон хууль, эрх зүйн актуудад нийцүүлэн өөрчлөх шаардлагатай шийдвэрүүдийг 2020 оны нэгдүгээр улиралд багтаан өөрчлөлт оруулан батлуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай шийдвэрүүдийн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100147

Аймгийн Засаг даргын 2020 оны 028 дугаар сарын 19-ны өдрийн 19 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ

Д/д	Шийдвэрийн огноо, дугаар	Шийдвэрийн тэргүү, утга	Хүчингүй болгох үндэслэл
1	2	3	4
1. Засаг даргын захирамж			
1	2011.03.01 Дугаар 49	Сумын хүн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн мэргэжилтэнд хариуцуулах тухай	Эмийн эргэлтийн сангуудыг хувьчлах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 59 дүгээр тогтоол гарч эмийн сангуудын үйл ажиллагаа хувьчлагдсан.
2	2011.11.02 Дугаар 331	Мал өвөлжилтийн бэлтгэлийг малчны хотонд хангуулах зөвлөмж батлах тухай	Эрх зүйн үндэслэл буюу захирамжид үндэслэсэн Засгийн газрын 2011 оны 192 дугаар тогтоол хүчингүй болсон.
3	2011.12.07 Дугаар 385	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон нутагт гүйцэтгэх чиг үүргийг Хууль зүйн хэлтсийн даргад хариуцуулах	Эрх зүйн үндэслэл өөрчлөгдсөн буюу орон тооны улсын байцаагч ажиллаж байгаа.
4	2012.03.15 а/91	Аймгийн Засаг даргын 2010 оны 390 дүгээр захирамжаар баталсан журмын 6.2 дахь заалт буюу Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд өөрчлөлт оруулсан	Захирамжид үндэслэсэн Засгийн газрын тогтоол нь хүчингүй болсон, мөн аймгийн шинэчлэгдсэн журам гарсан /Аймгийн Засаг даргын 2017 оны А/552 дугаар захирамж/
5	2012.03.28 а/115	Өвөрхангай аймгийн улс, аймаг, сумын хамгаалалтын зэрэглэлтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн сангийн жагсаалт	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж тус хуулиар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг батлахаар өөрчлөлт орсон. /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08/07 дугаар тогтоол/
6	2012.05.10 А/190	Удирдах зөвлөл байгуулах тухай (аймгийн эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн)	Эмийн эргэлтийн сангуудыг хувьчлах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 59 дүгээр тогтоол гарч эмийн сангуудын үйл ажиллагаа хувьчлагдсан.

7	2013.06.14 а/204	Салбар зөвлөл байгуулах тухай (Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги /2012-2020/ төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөл)	Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги” нь Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон. (Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлагдсанаар)
8	2015.01.13 а/05	Ажлын уялдаа, холбоог сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь 2016 онд хүчингүй болсон.
9	2015.02.17 а/55	Орон нутагт зохион байгуулагдаж байгаа хурдан морины хавар, зуны уралдаануудын үед хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээгч талуудтай хамтран ажиллаж, хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн	
10	2016.06.06 а/306	Орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратегийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Эрүүл хүнс, Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөр батлагдан стратегийн баримт бичгийг хүчингүй болгосон.
11	2014.02.28 А/82	Ажлын хэсэг байгуулах тухай (“Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2014 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хэсэг)	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 16 дугаар тогтоолоор “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөр шинэчлэгдэн аймгийн Засаг даргын 2018 оны “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/524 дүгээр захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дахин шинэчилсэн.
12	2015.04.07 а/136	Авто тээврийн чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	Эрх зүйн үндэслэл хүчингүй болсон.
13	2014.05.01 А/192	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг	Захирамжид Засгийн газрын 2013 оны 425 дугаар тогтоолыг үндэслэсэн бөгөөд уг тогтоол нь

		аймгийн хэмжээнд зохицуулах чиг үүрэг бүхий "Аймгийн эрүүл мэндийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүн, ажиллах журам	Засгийн газрын 2016 оны "Тогтоол хүчингүй болгох тухай" 150 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.
14	2018.01.09 А/03	Дүрэм батлах тухай (Соёл урлагийн ажилтны ёс зүйн дүрэм)	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" шинэчлэгдсэн.
15	2012.05.04 а/177	Салбар хороо байгуулах, дүрэм батлах тухай (Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт салбар хорооны бүрэлдэхүүн, дүрэм)	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний зөвлөлийн 2015 оны 04 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн салбар хорооны дүрмийг баталсан.
16	2011.03.03 Дугаар 51	Байгаль орчны зөвлөл байгуулах тухай	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэрээр баталсан бөгөөд ихэнх гишүүдийн ажил, албан тушаал өөрчлөгдсөн мөн төслийн хүрээнд байгуулагдаж төслийн хэрэгжих хугацаа дууссан.
17	2011.10.12 Дугаар 312	Аймгийн эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх нь хөтөлбөрийн хүрээнд байгуулсан бөгөөд хөтөлбөр хэрэгжиж дууссан.
18	2015.10.30 а/456	Сургагч багш томилох тухай (Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сургалт явуулах сургагч багш нар)	"Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөр" нь 2013-2015 онд хэрэгжихээр батлагдсан бөгөөд хугацаа нь дууссан.
19	2016.03.29 а/148	Орон тооны бус "Боловсролын зөвлөл" байгуулах тухай	Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгуулагдсан бөгөөд хөтөлбөр хэрэгжиж дууссан.
20	2017.01.24 а/13	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай (Японы нийгмийн хөгжлийн сангаас хөдөөгийн сумдын малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах төслийг хэрэгжүүлэх)	Төсөл хэрэгжиж дууссан.
21	2012.12.25 а/452	Комиссын бүрэлдэхүүн батлах тухай (Аймгийн	Аймгийн Засаг даргын 2019 оны "Аймгийн Онцгой комиссын

		Онцгой комиссын бүрэлдэхүүн)	бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” А/38 дугаар захирамжаар шинэчлэн баталсан.
22	2014.06.05 А/250	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн ажлын хэсэг	Аймгийн Засаг даргын 2018 оны “Залуучуудын хөгжлийн аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” А/181 дүгээр захирамжаар гарсан.
23	2016.01.11 а/05	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Аймгийн Засаг даргын 2017 оны “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл байгуулах тухай” А/189 дүгээр захирамжаар гарсан.
24	2016.04.12 а/196	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлын хэсэг	Аймгийн Засаг даргын 2018 оны “Зөвлөл байгуулах тухай” А/186 дугаар захирамжаар гарсан
25	2018.02.06 А/54	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог батлах тухай	Аймгийн Засаг даргын 2018 оны “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог батлах тухай” А/482 дугаар захирамжаар гарсан.
26	2019.12.05 А/741	Сургалтад оролцуулах тухай	Арга хэмжээ цуцлагдсан.
27	2019.12.20 А/792	Гадаадад албан ажлаар томилон ажиллуулах тухай	Арга хэмжээ цуцлагдсан.
2.Албан даалгавар			
28	2016.11.17 Дугаар 02	Төсвийн сахилга хариуцлагын тухай	Үйл ажиллагаа тогтмолжсон.

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/12 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ, ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ
ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ


Д/д	Шийдвэрийн огноо, дугаар	Шийдвэрийн тэргүү, утга	Үндэслэл
1	2011.11.16 Дугаар 351	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай	Барилгын тухай хууль 2016 онд өөрчлөн найруулагдаж эрх зүйн зохицуулалт өөрчлөгдсөн тул хуульд нийцүүлэн шинэчлэх
2	2012.01.24 а/20	Аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн “Суудлын автомашин ашиглах шинэчилсэн журам”, болон “Өмч хамгаалах байнгын зөвлөл” түүний ажиллах журам	Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоол нь Засгийн газрын 2015 оны “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон тул журмыг шинэ журамд нийцүүлэн шинэчлэх.
3	2011.12.12 Дугаар 389	Салбар хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай (Өвөрхангай аймгийн Хөдөлмөрийн маргаан шуурхай зохицуулах салбар хороо)	Бүрэлдэхүүнийг нэрээр баталсан бөгөөд ихэнх гишүүдийн ажил, албан тушаал өөрчлөгдсөн.
4	2012.03.20 а/99	Аймгийн газар хөдлөлтийн эрсдлийг бууруулах байнгын ажиллагаатай зөвлөл болон “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам”-	Аймгийн Засаг даргын 2017 оны “” А/103 дугаар захирамжаар дэд зөвлөлийг дахин баталсан тул захирамжийг хүчингүй болгож уг журмуудыг онцгой комиссын журамд нийцүүлэн гаргах буюу өөрчлөн шинэчлэх
5	2013.10.08 а/352	Комисс байгуулах тухай (ХАҮТ-ын “Өвөрхангайд үйлдвэрлэв” бүтээгдэхүүн зуучлал, борлуулалтын төвд “бүтээгдэхүүний шалгуур” тогтоох ажлын хэсгийн комисс)	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль нь 2019 онд хүчингүй болсон тул шинэ хуульд нийцүүлэн зорилтот жилтэй уялдуулан шинэчлэх
6	2014.01.20 А/24	Журам батлах тухай (Өвөрхангай аймгийн камерын хяналтын системийн ажиллах журам)	Камерын хяналтын нэгдсэн системийг өргөжүүлсэн тул шинэчлэх
7	2014.03.21 А/124	Хороо шинэчлэн байгуулах тухай (Хөгжлийн	Хөтөлбөр дууссан боловч зарим үйл ажиллагаа нь үргэлжлэн

33	Хайрхандулаан	Д.Хорлоо	ТҮБД-5-5	964899	20	25	15
34	Хархорин-1	Ц.Баасансүрэн	ТҮБД-5-5	964899	20	25	15
35	Хархорин-2	Д.Нарантуяа	ТҮБД-5-5	964899	25	25	15
36	Хархорин-3	А.Сүрэнхорлоо	ТҮБД-5-1	885763	20	5	15
37	Хархорин-4	П.Осорхүү	ТҮБД-5-5	964899	25	25	15
38	Хархорин-5	Б.Байгалмаа	ТҮБД-5-1	885763	20	15	15
39	Хужирт-1	З.Оюунчимэг	ТҮБД-5-4	938498	25	25	15
40	Хужирт-2	Ш.Эрдэнэхорол	ТҮБД-5-2	893200	20	10	15
41	Хужирт-3	Д.Норов	ТҮБД-5-4	938498		15	15

-oOo-

		бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн аймгийн хороо)	хэрэгжиж байгаа тул шинэчлэх
8	2016.08.25 а/371	Сонгон шалгаруулалтын журам батлах тухай (ЕБС, СӨББ-ын багшийг сонгон шалгаруулах)	Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай.
9	2017.12.27 а/588	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай	1. Захирамжийн нэгдүгээр хавсралт буюу дүрмийг шинэчлэх шаардлагатай. 2. Захирамжийн хоёрдугаар хавсралт буюу бүтэц, орон тоо баталсныг хүчингүй болгох. Учир нь 2019 оноос ХХААХҮЯ бүтэц, орон тоог баталж байгаа.
10	2014.04.23 А/170	Дэд зөвлөл байгуулах тухай (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх аймгийн зөвлөл)	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 17-ны өдрийн 474 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШИЙДВЭРИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Шийдвэрийн огноо, дугаар	Шийдвэрийн тэргүү, утга	Үндэслэл
1	2017.07.04 а/339	“Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020”	Цаашид биелэлтийг тооцож ажиллах
2	2014.06.17 А/268	Зөвлөл байгуулах тухай (Орхоны хөндийн Байгалийн цогцолборт Газрын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл)	Эрчимжүүлэх
3	2015.11.13 а/472	Хүн, малын эрүүл мэндийн болон бусад салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрдүүлэх зорилгоор “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн аймгийн салбар зөвлөл болон техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам	Эрчимжүүлэх
4	2018.03.28 А/190	Орон тооны бус зөвлөл байгуулах тухай (Барилга байгууламжийн паспортжуулах үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус паспортжуулалтын зөвлөл)	Эрчимжүүлэх